

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
ӨНӨД ТҮНШ ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЦЭНДСҮРЭН

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ
ОРШИХ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС БАЙГУУЛАХ
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН ШИНЖЭЭЧ

З.АЗЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ӨНӨД ТҮНШ ХХК-НИЙ МЕНЕЖЕР

М.БУМЦЭНД

2025 он

**ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН**

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	30
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	34
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	36
13. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ НИЙТ ТӨСӨВ	38

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.1. Төслийн нэр: “Гаалийн хяналтын бүс байгуулах” төсөл

“Өнөд түнш” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 1111017297

1.1.2. Төсөл

хэрэгжүүлэгч:

- Регистрийн дугаар: 3655318
- Хаяг: Өмнөговь аймаг, Гурвантэс сум, 4-р баг, Урт, үйлчилгээ 2, 211 тоот
- Утас: 89018917, 96151696


1.1.3. Төслийн зорилго

“Өнөд Түнш” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн зорилго нь Гаалийн хяналтын бүсэд нүүрс буулгаж, хадгалж, ачих үйл ажиллагаа явуулах ба орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, Монгол улсын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй хууль, дүрэм журмыг сахин биелүүлж урт хугацааны туршид Монгол улсын эдийн засаг, гадаад худалдааны тэнцэлд хувь нэмрээ оруулж, нүүрс тээвэрлэлт, логистикийн салбарт аюулгүй ажиллагааг эрхэмлэн, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахад оршино.

1.2. Төслийн талбайн байршил

“Гаалийн хяналтын бүс байгуулах” төсөл нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг буюу Бага-Овоо багийн нутаг Морин заг суурьшлын бүсэд хэрэгжинэ. Төслийн талбай нь Нарийн сухайтын бүлэг ордоос 30 орчим км зайд, Шивээхүрэн хилийн боомтоос 17.5 км зайд байрлана.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН



Зураг 1 Төслийн талбайн байршил

Хүснэгт 1 Төсөл хэрэгжих талбайн солбицол

№	х	у
1	684822.03	4734651.87
2	685020.82	4734673.88
3	685103.74	4733928.48
4	684904.96	4733906.37
15 га		
5	685020.82	4734673.88
6	684822.03	4734651.87
7	684794.51	4734900.35
8	684993.30	4734922.36
5 га		
Нийт төсөл хэрэгжих талбайн хэмжээ: 20 га		

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

1.3. Төслийн хүчин чадал

Төслийн нийт хамрах хүрээ 20 га талбайд хэрэгжих бөгөөд 183.3м*588м харьцаатай 10.8 га талбайд өдөрт дунджаар 40,000 тн ачаа буулгаж, ачих хүчин чадалтай байхаар төлөвлөж байна. Төслийн хэрэгжилтийн эхний шатанд өдөрт 33,400 тн орчим, сард 1,000,000 тн орчим нүүрс буулгаж, мөн тухайн хэмжээний нүүрсийг ачиж, Шивээхүрэн боомтоор нэвтрүүлнэ.

Үйлчилгээний төрөл	нэрХэмжих нэгж	Хоногт ажиллах хүчин чадал	Жилд ажиллах хоног	Жилийн хүчин чадал
Нүүрс	тонн	40,000	300	12,000,000

Тайлбар: Талбайн эргэлтийн хүчин чадлаараа жилд 12,000,000 тн нүүрс гаргах хүчин чадалтай.

1.4. Ажиллах хүч

“Гаалийн хяналтын бүс байгуулах” төсөл нь нийт 80 ажилтантай байх ба ажилчдын орон тоо өндөр байх албан тушаал нь чингэлэг өргөгчийн оператор, пүүний оператор, дугуйт ачигчийн оператор, хөдөлгөөн зохицуулагч зэрэг байна. Төслийн талбайд ажиллах ажилчид нь Хөдөлмөрийн тухай хуулийн 3дугаар бүлэг 92 зүйлд зааснаар уртын ээлжээр ажиллах буюу ажилтны нэг ээлжинд ажил үүрэг гүйцэтгэх хугацаа 14 хоног, амрах хугацаа 14 хоног байх ба ажилчид нь гэрээт кемп-д байрлана.

Хүснэгт 2 Төслийн ажиллах хүч

Албан тушаал	Ажилчдын орон тоо
Гаалийн хяналтын бүсийн менежер	2
Ээлжийн ахлах	4
Мэдээлэл технологийн инженер	2
Чингэлэг өргөгчийн оператор	12
Индүүний оператор	2
Гаалийн бүрдүүлэлтийн ажилтан	2
Пүүний оператор	16
Дугуйт ачигчийн оператор	12

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Хөдөлгөөн зохицуулагч	16
Усны машины жолооч	2
Аж ахуйн ажилтан	2
Үйлчлэгч	2
ХЭМААБО-ны менежер	2
ХЭМААБО-ны ажилтан	4
Нийт	80

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүй: Төсөл хэрэгжих талбай нь бүс нутгийн газарзүйн байршлын хувьд Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрлаж Говь-Алтайн нурууны цаад цөлөрхөг бүсэд орших ба өндөр сүрлэг уулс, говь, тал, хөндий хоолойнууд олонтой бүс нутагт хамаарна.

Уур амьсгал: Тус төслийн талбай орчмын газар нутгийн жилийн дөрвөн улирлын төлөв байдал нь Монгол орны хойд хэсэг, Хангайн бүсээс эрс ялгаатай байдаг онцлогтой. Энд зуны улирал нартай, халуун-хуурай, заримдаа маш бүгчим, үргэлжлэх хугацаа нь өвлөөс 2 дахин урт байдаг. Хаврын улиралд огцом дулаан болж, хамгийн олон өдөр шороон ба элсэн шуургатай, нэн хуурай болдог. Хаврын хүчтэй салхины нөлөөгөөр хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж, уур амьсгалын зарим талын зохисгүй сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Харин намар нь зөөлөн дулаан ба намрын сүүлчээр сэрүүсэж, салхины хүч нэмэгддэг. Хавартаа маш хуурай бөгөөд салхи, шуурга ихтэй байна. Бүс нутгийн агаарын үнэмлэхүй их температур зуны улиралд 29-33°C, өвлийн улиралд хамгийн багадаа цельсийн -10 хэм хүртэл хүйтэрдэг байна.

Усан орчин: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших төслийн талбай нь ус зүйн мужийн тухайд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтах бөгөөд Монгол орны усны 29 сав газрын (БОАЖЯ, 2009) Алтайн өвөр говийн сав газарт хамаарах ба энэ сав газар нь нийт 211.156 км² талбайг хамран оршино. Төсөл хэрэгжих Гурвантэс сумын нутаг нь ус зүйн сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км²-ээс доош байдаг. Гол мөрний нийлбэр урсац 5мм-ээс доош, харин гадаргын урсац болон газар доорх урсац нь 5мм-ээс доош, жилийн дулаан үеийн ууршилт 1000мм-ээс дээш хэмжээтэй байна. Гол мөрний усны горимын хувьд зуны хур борооны усаар үерлэдэг сайр их тогтдог. Үүнд газар доорх ус 10%, хур борооны ус 90%-ийг эзэлдэг. Шивээхүрэн боомтын орчимд гадаргын усны эх үүсвэр болох булаг шанд, нуур тойром, гол горхи бүртгэгдээгүй байна.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн Говийн их мужийн холимог бүсшилийн хэв шинж бүхий Говийн их мужийн өргөргийн бүсшилийн хэв шинж бүхий цөлийн бор саарал хөрсний 15-р тойргийн нутагт хамрагдана. Дээрх тойргуудад дундаж өндөртэй, хад асга бүхий уулсаар сул хөгжилтэй, сайр чулуурхаг, уулын цөлөрхөг хээрийн цайвар бор хөрс, уулс хоорондын уудам хөндий болон ухаа гүвээт толгодоор заримдаг цөлийн цайвар бор хөрс, говийн бор хөрс тархах бол уулан дундах хуурай сайр, уулын бэлийг хэрчиж тогтсон хуурай сайруудаар сул хөгжилтэй сайрын элсэн хөрс тархах бөгөөд сайр өргөжин гүн багасах үед арал хэлбэрээр хэт хуурай цөлийн борзон болон цөлийн гөлтгөнөт бор хөрс өргөн тархалттай тохиолдоно.

Сүүлийн жилүүдэд говийн бүс нутагт уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрчимжиж, тэр хэмжээгээр газрын гадаргын төрх байдалд өөрчлөлт орж, улмаар нэлээд хэмжээний газар нутагт хурдас чулуулгийн овоолго шороо, ухагдсан нүх, карьерууд бий болсон нь тухайн бүс нутгийн хөрс, ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх болсон байна. Тухайлбал, нүүрс, зэс болон бусад байгалийн баялгийг хамгийн ойр байрлах БНХАУ-руу тээвэрлэхэд олон тооны шороон замууд бий болсон нь говийн эмзэг хөрсийг доройтуулж, хөрсний жижиг хэсгүүд салхиар зөөгдөж эвдрэлд орох нөхцөлийг бүрдүүлсээр байна. Мөн малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн даац хэтэрч байгаа учраас элсжилт нэмэгдэх, худаг уст цэгүүд орчмын хөрсний талхагдал доройтол ихсэж байна.

Ургамлан нөмрөг: Өмнөговь аймгийн Гурвантэс суманд байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Алтайн өвөр говийн цөлийн тойрогт хамаарагддаг. Төслийн талбай нь цөлийн ургамалжилтай. Энэ тойрогт 383 зүйл ургадгаас зөвхөн 12 зүйл ургамал байдаг.

Амьтны аймаг: Төслийн талбай орчим нь Монгол орны хөхтөн амьтдын тархцын мужлалаар Алтайн өвөр говийн тойрогт хамаарагдаж байна. Төслийн талбай нь говийн нам уулс, толгод хоорондын хөндий хотос газарт байрлана. Шивээхүрэн боомтыг түшиглэсэн суурьшлын бүс, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хатуу хучилттай зам зэргийн нөлөөгөөр амьтдын амьдрах орчин хуваагдаж, амьтдын тархац нутаг хумигдсан. Хээрийн судалгааны явцад тус төслийн талбай орчимд хар сүүлт зээр, бор туулай гэсэн 2 зүйл хөхтөн амьтныг бүртгэсэн. 13 зүйлийн шувуу бүртгэгдсэн бөгөөд 13 зүйл шувуудын дотор Олон улсын хэмжээнд “Эмзэг” Нөмрөг тас байгаа бол Бүс нутгийн хэмжээнд “Эмзэг” Монгол хулан жороо байна. Мөлхөгч амьтан бүртгэгдээгүй болно.

**ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН**

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг буюу Бага-Овоо багийн нутагт хэрэгжих “Гаалийн хяналтын бүс” байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээний талаар авч үзнэ. Бүлэг тус бүрд дараах мэдээллүүд багтсан. Үүнд:

- Нөлөөллийн эх үүсвэрүүд /гол асуудлууд/ болон нөлөөллийн тухай
- Үнэлгээний орон зайн цар хүрээ, техникийн болон цаг хугацааны хамрах хүрээний тодорхойлолт
- Төслийн үргэлжлэх бүхий л хугацааны туршид үүсэж болзошгүй нөлөөллийн тодорхойлолт болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Нөлөөллийн үнэлгээг үнэлгээгээр тодорхойлсон хүлээн авагчид буюу нөөцөд үзүүлж болзошгүй нөлөөллийн зэрэглэлийг үнэлгээний шалгуурын дагуу тогтоож үнэлэн, болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, төслийн үр шимийг дээшлүүлэх арга хэмжээ боловсруулав.

Хүснэгт 3 Нөлөөллийн шинж чанар, төрөл

Шинж чанар, төрөл	Тодорхойлолт
Эерэг	Суурь нөхцөлийг сайжруулж, эерэг өөрчлөлт бий болгох нөлөөлөл
Сөрөг	Суурь нөхцөлийг дордуулж, таагүй шинэ хүчин зүйл бий болгох нөлөөлөл
Шууд	Төслийн төлөвлөсөн үйл ажиллагаа болон байгаль орчин/хүлээн авагчид хоорондын шууд харилцаанаас үүссэн нөлөөлөл
Дам	Төслийн үр дагавраар бий болох бусад үйл ажиллагаанаас үүсэх нөлөөлөл

Нөлөөллийг “зэрэглэл”-ээр нь авч үзвэл: Нөлөөллийн хэмжээ, нөлөөлөл үүсэх магадлалыг зэрэглэл гэнэ. Нөлөөллийн хэмжээ (заримдаа хүндрэлийн зэрэг гэдэг) гэдэг нь нөлөөллийн цар хүрээ, үргэлжлэх хугацаа, эрчим юм. Хүснэгт 20-д нөлөөллийн зэрэглэл тодорхойлох шалгуурыг тоймлон харуулав. Нөлөөллийн хэмжээ, магадлалыг тогтоосны дараа нөлөөллийн зэрэглэлийг Хүснэгт 18 болон Хүснэгт 19-д заасан матрицаар тогтоов.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

Нөлөөллийн зэрэглэлийг итгэл үнэмшлийн (итгэлцүүрийн зэрэг) зэргээр тодорхойлдог. Таамаглалын итгэл үнэмшил нь тодорхойгүй байдал юм. Тухайлбал нөлөөллийн үнэлгээ хийхэд мэдээлэл дутмаг байх. Итгэл үнэмшлийн зэргийг бага, дунд, өндөр хэмээн илэрхийлдэг.

Хүснэгт 4 Зэрэглэлийн тодорхойлолт

Зэрэглэлийн тодорхойлолт	
Маш бага	Тодорхой үйл ажиллагаанаас байгалийн нөөц болон хүлээн авагч ямар ч нөлөөлөлд өртөхөөргүй маш бага хэмжээний нөлөөллийн зэрэглэл. Эсвэл таамаглаж буй нөлөө нь “маш бага”, “үл мэдэгдэх”, “ажиглагдахгүй” нөлөөлөл.
Бага	Нөлөө үүсэх боловч түүний хэмжээ нэлээн бага бөгөөд нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн ч бай, хэрэгжүүлээгүй байсан ч стандартын түвшинд байна. Хүлээн авагчид үзүүлэх нөлөөлөл бага.
Дунд	Стандартын түвшинд байна. Нөлөөллийг хамгийн бага боломжтой түвшинд хүргэж бууруулах боломжтой. Гэхдээ энэ нь “Дунд”-аас “бага” нөлөөлөлд хүргэнэ гэсэн ойлголт биш хэдий ч нөлөөлөл бууруулах арга хэмжээг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх боломжтой.
Их	Стандартын түвшнээс хэтэрч магадгүй ба өндөр ач холбогдолтой/мэдрэмтгий нөөц/хүлээн авагч их хэмжээний нөлөөлөлд өртөнө. БОННУ-ний зорилго нь Төслөөс үлдэгдэл нөлөөлөл гаргахгүй байх, удаан хугацаанд үргэлжлэх, том газар нутагт илрэх нөлөөлөл үүсгэхгүй байхад чиглэнэ. Нөлөөлөл бууруулах бүх боломжит арга хэмжээ авсан ч зарим томоохон нөлөөлөл үлдэж болзошгүй. Бүтээн байгуулалтын нөлөөлөл үүнд орно. Төслийн талаар шийдвэр гаргахад эдгээр сөрөг хүчин зүйлийг хөдөлмөр эрхлэлт зэрэг эерэг хүчин зүйлтэй харьцуулах нь зохицуулагч, оролцогч талуудын үүрэг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

“Гаалийн хяналтын бүс” байгуулах төслийн бүтээн байгуулалтын явц болон төслийн хэрэгжилтээс агаарын чанар, хөрс, газрын доорх ус, ургамлан нөмрөг болон амьтны аймаг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүр дээр тооцсон ба нийт 24 болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон. Үүнээс 13 буюу 54% нь бага, 9 буюу 38% нь дунд, 2 буюу 8% нь их гэсэн нөлөөллийн зэрэглэлд хамаарагдаж байна. Төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд их сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа бага байна. (Хүснэгт 33).

Хүснэгт 5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт

**ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН**

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
	Бага	Дунд	Их	
Агаарын чанар	3	4	1	8
Хөрсөн бүрхэвч	4	2	1	7
Усан орчин	3	1	-	4
Ургамлан нөмрөг, Амьтны аймаг	3	2	-	5
Нийт (тоогоор)	13	9	2	24
Нийт (хувиар)	54	38	8	100.00

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан. Хуулийн дээрх шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав. Гаалийн хяналтын бүс байгуулах төслийн БОМТ-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-д заасны дагуу хийж гүйцэтгэсэн.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах									
1.1.	Хөрс хуулалт газар шорооны ажил явагдсанаар орчны агаарт тоосжилт үүсэх	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед газар шорооны ажлыг түр зогсоох	Төслийн талбай	-	-	-	Зардал гарахгүй	Салхины хүч ихээр нэмэгдэх үед	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм
1.2.	Бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд ашиглагдах машин механизмаас ялгарах хорт утаа нь агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Ашиглагдаж буй машин техникийг үзлэгт хамруулах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх	Төслийн хэмжээнд ашиглаж буй өөрийн машин, механизм, генераторууд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Барилгын ажлын хугацаанд	
1.3.	Бүтээн байгуулалтын явцад тоосжилт үүсэх	Бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явцад тоосжилт үүсгэж болзошгүй бараа материалыг зөв битүү эсвэл	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Барилгын ажлын хугацаанд	

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		зориулалтын аргаар зөөж тээвэрлэх, 10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед дээрх бараа материалыг хянах, тоос дэгдэхгүй байх талаас нь арга хэмжээ авах							хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
1.4.	Бүтээн байгуулалтын явцад барилгын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Бүтээн байгуулалтын үед машин техник зорчсон хатуу хучилтгүй зам талбайг тогтмол услах.	Төслийн талбай	-	-	-	255,000	Жилд 12 удаа	MNS 4990:2015 ХАБЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
1.5.	Талбайд нүүрс ачиж, буулгаж, хадгалах үед агаарт нүүрсний тоосжилт үүсэх	Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайг тойруулан 6-7м өндөртэй салхинаас хамгаалалтын торон хашааг байгуулах, эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд тухай бүрд засварлах	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа	

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

1.6.	Үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт	Төслийн үйл ажиллагаа, машин техникийн хөдөлгөөнөөс үүдсэн тоосжилтыг зориулалтын бодис ашиглан дарах	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Барилгын ажил болон үйл ажиллагаа явуулах хугацаанд	Бензин хөдөлгүүр тэй автомаши н. Утааны найрлага дах хорт
1.7.	Бүтээн байгуулалтын явц, машин механизмын хөдөлгүүрээс дуу чимээний бохирдол үүсэх	Барилгын ажлыг 07:00 18:00 цагийн хооронд гүйцэтгэх	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Барилгын ажлын хугацаанд	бодисын зөвшөөрөг дөх дээд хэмжээ ба хэмжих арга Агаарын чанар, хот
1.8.	Барилгын материал, ажиллах хүч, тоног төхөөрөмжийг төслийн талбай руу тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн түлшний шаталтаас CO, SO2, NOx болон PM10 зэрэг агаар бохирдуулагчид ялгарна.	Төслийн талбай дотор, тээврийн зам дагуу, хог хаягдлыг цэг орчимд болон тээврийн машины зогсоолын орчимд агаарын бохирдуулагчийг хэмжих хяналтын цэг байгуулж, хэмжилт хийх	Төслийн талбай	-	-	-	300,000	Барилгын ажлын хугацаанд нэг удаа	суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуул ах бодисын хүлцэх хэм хэмжээ

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

1.9.	Ажилчдын ахуйн хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд түр хадгалаагүй болон тогтмол төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зөөвөрлүүлээгүйн улмаас агаар бохирдох	Хогийг ангилах, зориулалтын хогийн саванд хаяж байх, тогтмол хог хаягдлын төвлөрсөн цэг рүү ачуулж байх. Хог хаягдлын гэрээний дагуу төлбөрийг төлөх	Төслийн талбай	-	-	-	1,300,000	Тогтмол
1.10.	Төслийн талбайд зочлох гадны тээврийн хэрэгсэл зогсох зогсоолын талбай байхгүйн улмаас машин техник зөвшөөрлийн бус талбайд зогсож хөрс талхлах, шаардлагагүй үед машин асаалттай байснаар түлш шаталтаас үүсэх агаар бохирдуулагч ялгарна.	Төслийн талбайд машин зогсох талбайг бэлдэх	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагаа эхэлсэн үеэс
2. Усан орчин (Гадаргын болон газрын доорх) үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах								

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

2.1.	Бүтээн байгуулалтын үе болон ажилчдын хэрэглээнд гүний ус ашигласнаар усны нөөцөд нөлөөлөх	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг хяналтын зарын самбарт, нийтийн бие засах газар байрлуулж шинэчилж байх	Төслийн талбай			-	280,000	Улиралд нэг удаа	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам
2.2.	Усыг зөвшөөрлийн бус эх үүсвэрээс, эрүүл мэндийн	Усыг зөвшөөрөгдсөн эх үүсвэрээс хангах буюу өрөмдмөл худаг гарган ашиглах.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөнд тусгав.						
2.3.	шаардлага хангаагүй ус хэрэглэх болон усны эх үүсвэртэй зүй зохисгүй харьцаж гачигдал, бохирдол үүсгэх	Ажилчдын ахуйн хэрэглээнд хэрэглэх ус ашиглалтыг хэмнэлттэй байлгах зорилгоор ус хэмнэгч цорго болон хошууг байршуулах							
3. Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах									
3.1.	Шатах, тослох материал нефтийн бүтээгдэхүүн алдагдах, асгаралт	ШТМ асгарах, алдагдах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах	Төслийн талбай, зогсоол	ш	600,000	1	600,000	Гүйцэтгэл ээр	Хог хаягдлын тухай хууль

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

	үүссэнээр хөрсөн бүрхэвч бохирдох	хэрэгслийг төслийн талбайд байрлуулах. /элс, хоо сон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг/							
3.2.		Хог хаягдлыг ангилан ялгаж гэрээт байгууллагаар сар бүр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан						
3.3.	Хатуу, шингэн хог хаягдлын улмаас хөрс бохирдох	Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан						Хог хаягдлын тухай хууль

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

3.4.	Доторлогоогүй бохирын нүх	Бохирын септик систем ашиглах	Ариун цэврийн байгууламж	ширхэг	5,000,000	2	10,000,000	Үйл ажиллагаа ны турш	MNS 4943 2015
3.5.	ашиглахад хөрсөнд нян, хөгц, мөөгөнцрийн бохирдол үүсгэнэ	Шингэн хаягдал хаях цооног /септик танк/ дах бохирдлын хэмжээг хянах, хэмжээ дүүрсэн үед соруулах	Ариун цэврийн байгууламж	Үйл ажиллагаа эхэлснээс хойш сард 1 удаа	150,000	10	1,500,000	Үйл ажиллагаа ны турш	
3.6.	Ажилчид засмал зам талбайгаар яваагүйн улмаас хөрс талхлагдах	Ажилчдыг засмал зам талбайгаар явахыг сануулсан тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбай	ширхэг	25,000	2	50,000	Үйл ажиллагаа ны турш	MNS 5916:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008,
3.7.	Шимт болон шимэрхэг хөрс талхлагдах, шимт хөрснийг технологийн дагуу бус хуулах хадгалах, хөрсний бусад үе давхаргатай холих зэргээс үүдэн шимт чанараа алдах	Төслийн газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, хадгалахдаа MNS 5916:2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт стандартыг хангах болон хөрс хуулах арга барилын талаар гэрээлэн	Төслийн талбай	овоолго	Үйл ажиллагаа ны зардал	-	Үйл ажиллагаан ы зардал оруулсан	Үйл ажиллагаа ны турш	MNS 5916:2008, MNS 5917:2008, MNS 5918:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008,

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		гүйцэтгэгч компанид тодорхой зааварчилгааг өгөн, тохиролцож ажиллах.							MNS 5918:2008,
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах									
4.1.	Төслийн хүрээнд бүтээн байгуулалт хийгдэж зарим талбайг хатуу хучилттай болгосноор ургамлан нөмрөг устаж шууд нөлөөлөлд өртөнө.	Бүтээн байгуулалт хийгдэх талбайн ургамлан нөмрөг шууд нөлөөлөлд өртөхөөр байгаа бөгөөд төслийн нийт хамрах талбайн зарим хэсэгт тухайн бүс нутгийн онцлогт тохирсон ургамлыг дүйцүүлэн тариалах. Төслийн талбайд олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэх	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгагдсан				Газар шорооны ажлын дараа	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо,	
4.2.	Амьтад дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн	Төслийн талбай				300,000	Оны эхний улиралд багтаан тээврийн бүх	тодорхойл олт MNS 5918:2023 “Эвдэрсэн газрыг

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

	нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих	дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих						ээлжийн жолооч нарыг хамруулж жолооч бүрд жилд нэг удаа	ургамалж уулах. Техникийн ерөнхий шаардлага ”.
4.3.	Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас мал амьтад тэжээл хайж ирэх орогнох, хордож болзошгүй	Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах, битүүмжлэлийг байнга хянаж шалгах	Төслийн талбай	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан					
	Нийт зардал							14,585,000	

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ногоон байгууламж байгуулах	2га талбайд үрсэлгээ хийж, бут сөөг тарьснаар орчны өнгө үзэмжийг сайжруулж тохижуулах	Эхний жилд 1 га талбайд ногоон байгууламж бий болгох	га	1000	3,000,000	3,000,000	Ургамал ургалтын хугацаанд	Газрын тухай хуулийн 56.6 Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4
2.	Ногоон байгууламжийн арчилгаа			нэгж	1000	1,000,000	1,000,000		
	Нийт						4,000,000		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Одоогоор төсөл хэрэгжих талбай орчимд барилга угсралт, газар шорооны ажлын явцад соёлын өв олдоогүй ч үйл ажиллагааны явцад олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сумын бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

Хэрэв үйл ажиллагааны явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар, олдворыг гэмтээхгүйгээр авран хамгаалах малтлага судалгааг хийлгэж ажиллана.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх	Мэргэжлийн байгууллагаар	1	-	Үйл ажиллагааны зардал	4 дүгээр улиралд багтаан	Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
2.	Газар хөдлөл	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших	Нэгж сургалт	1	Жилд 1 удаа	ХАБЭА-н зардлаас	3 дугаар улиралд	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах						
3.	Аянга цахилгаан	Аянга газардуулагчийг агаарын шугамын орчинд суурьшуулсан байх	Төслийн талбай	1	600,000	600,000	2025 онд хэрэгжүүлэх	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа.
4.	Үер	Хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Газрын өндөрлөг талын хашааны урт?	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал	2 дугаар улиралд багтаан	Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм
5.	Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга самбарыг шинээр барьж буй объект бүрд онцлогийг нь тусган тавих. Гал унтраах багаж	Галын аюул үүсэж болзошгүй байршил	20	100,000	2,000,000	2 дугаар улиралд	MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал.

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		хэрэгслийн иж бүрдэл, галын сарайг бэлэн байлгах.						Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000
6.	Халдварт өвчин	Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдын хувийн эрүүл ахуйг сахих дадал зуршлыг хэвшүүлэх талаар мэдээлэл олгох сургалт зохион байгуулах	Нийт ажилчид болон хоол үйлдвэрлэлийн ажилчдад	2	50,000	100,000	ХАБЭА-н батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага. MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

								MNS 5566:2020 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
7.		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Нийт ажилчид	ХАБЭА-н зардлаас				
8.	Үйл ажиллагааны осол гэмтэл	Бүх ажилчдад ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хамрагдаагүй ажилчдыг тухайн	Нийт ажилчид	-	-	-		

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		өдөрт ажиллахыг хориглох						
9.		Анхан тусламжийн багаж, эмийн санг шинэ ажилчдын байранд байрлуулах	Шинэ ажилчдын ажлын байранд	1 багц	300,000	300,000	Үйл ажиллагаа эхлэх үед	
10.	Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарах	Тоног төхөөрөмжийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх.	Нийт ашиглах ТТ, ММ тоо оруулах	-	-	-	Үйл ажиллагааны турш	
	Нийт					3,000,000		

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн хог хаягдал	Хог хаягдал түр хадгалах цэг, ангилан ялгалттай хогийн савыг байрлуулах	Төслийн талбай	Нэгж	500,000	10	5,000,000	2025 онд хийж гүйцэтгэнэ	Хог хаягдлын тухай хууль; Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий
2.		Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх		Удаа	-	Сард 1 удаа	360,000	Үйл ажиллагаа эхлэх үед сар 1 удаа	
3.		Хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдлыг гэрээт ААН (тохижилт үйлчилгээний ОНӨААТҮГ)-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Гэрээт байгууллага	Удаа	50,000	12	600,000	Үйл ажиллагаа эхлэх үед сар 1 удаа	

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

4.		Ажилчдад хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаар дадал зуршил эзэмшүүлэх сургалтад хамруулах, мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах	Оффис	ширхэг	75,000	2	150,000	2-3 дугаар улиралд	шаардлага MNS 5344 : 2011 стандарт; Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам,
5.	Аюултай	Машин, техникийн төмөр сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг тусгай талбайд хуримтлуулан дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагаа эхлэх үед мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулна	
		ШТМ, тос тосолгооны материалын сав баглаа боодол, ШТМ арчсан даавуу зэргийг аюултай хог	Төслийн талбай	-	-	-	-	Үйл ажиллагаа эхлэх үед мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулна	

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		хаягдлыг хадгалах, устгах цэг рүү зөөвөрлөх							
	Нийт						6,110,000		

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар чанар								
1.	Тоосжилт (PM10, PM2.5); орчны дуу шуугиан; Агаар бохирдуулагчийн SO ₂ , NO ₂ , CO;	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай цэгт (нүүрс буулгах талбай, ажилчдын оффис, авто зогсоол)	Жилд 2 удаа	2	200,000	400,000	Эх үүсвэрүүдийн байршил, нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан төслийн талбайд арга зүйн дагуу	MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага; MNS 3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ; MNS 3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга; MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага; MNS 0012-1-015:1987. Чимээ шуугиан–Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга; MNS

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

								0017.2.5.12:1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь хүхэрлэг хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS 0017.2.5.11-1988. Байгаль хамгаалал. Агаар мандал. Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга; MNS 5365:2004 Агаарын чанарын ерөнхий асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга;
Хөрсөн бүрхэвч								
2.	Ялзмаг, урвалын орчин (рН), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O),	Хогийн цэг, төслийн талбайн хатуу хучилтгүй талбай болон төслийн талбайн	Жилд 4 удаа 3 цэгт дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Жилд 4 удаа	300,000	1,200,000	Итгэмжлэгдсэн лабораторийн дэлгэрэнгүй шинжилгээ	MNS 2305:1995 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298:1991 Шинжилгээний дээж авахад

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

	хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), механик бүрэлдэхүүн	гадна талд нийт 3 цэгт						тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
Ургамлан нөмрөг								
3.	Ургамлын зүйлийн тоо, арви бүрхэц, төслийн гаднах талбайн биомасс зэргийг гаргана	Төслийн талбайд байх ургамлан нөмрөг бүхий талбай болон төслийн талбайн гадна	1 удаа	1 удаа	300,000	300,000	Дижитал зургийн аппарат, хээрийн судалгааны мэдээ цуглуулах маягтууд, харандаа, туузан метр, хатгуур, төмөр гадас, ашиглан тооллого, хэмжилт хийх аргаар	Ургамлын бичиглэл хийх, бүрхцийг тодорхойлох аргачлал
Усан орчин								

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

4.	Усны хими болон физикийн үзүүлэлт, pH, Эрдэсжилт, ЦДЧ, химийн үндсэн анион ба катион, умбуур бодис, хатуулаг, хүнд металлын агууламж, As, Ba, Be, B, Cd, Co, Cu, Cr, Ag, Se, Mo, Mn, Hg Pb, Zn, Ti	Үйл ажиллагаанд ашиглах худгийн ус	Улиралд 1 удаа	4	100,000	400,000	Усны дээжийн сав хэмжээ: 1000 мл Усны дээж авах ган ховоо хэмжээ: 1000 мл, лабораторийн шинжилгээ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
5	Эрүүл ахуй, бичил амьсудлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо (эмгэг төрүүлэгчийн тоо), өвчин үүсгэгч нян	Унд ахуйн усны эх үүсвэрүүд, гал зуухны угаалтуурын цоргоноос	Сард 1	Үйл ажиллагаа эхэлснээс хойш	100,000	1,200,000	100 мл ариутгасан зориулалтын сав Лабораторийн шинжилгээ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
	Нийт					3,500,000		

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	-	1 дүгээр улиралд	Байгаль орчны мэргэжилтэн, Удирдлага	
2.	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөглөх	-	Үйл ажиллагаа эхлэх үед	Байгаль орчны мэргэжилтэн, Кемп менежер	
3.	Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	200,000	4дүгээр улиралд багтаан	ХАБЭА ажилтан	
4.	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлага болон орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна	-	2 дугаар улиралд	ХАБЭА ажилтан	
5.	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	-	2 дугаар улиралд	Удирдлага, ХАБЭА ажилтан	

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

6.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах.	ХАБЭА-н зардлаас	3 дугаар улиралд	Удирдлага, Хүний нөөц	
7.	Ажлын онцлогоос хамааруулан хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	200,000	Үйл ажиллагааны турш	Санхүү, ХАБ	
8.	Гал унтраах хэрэгслээр засварын төвийн объектыг бүрэн хангах, гал түймэр унтраах талаар ажиллагсдыг сургах	ХАБЭА-н зардалд багтсан	Тогтмол	Удирдлага, ХАБЭА ажилтан	
9.	Төслийн талбайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын талаарх мэдээлэл бүхий самбарыг байршуулах, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчилж байх	100,000	Тогтмол	Удирдлага, ХАБЭА ажилтан	
10.	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 101 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	3 дугаар улиралд	Байгаль орчны мэргэжилтэн	
11.	Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах		Удирдлага, Санхүү, Хүний нөөц	
	Нийт	500,000			

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн бичвэр байна. Тухайн бичвэр ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	12 дугаар сарын 30-наас өмнө	100,000	Байгаль орчны мэргэжилтэн	БОУАӨЯ
2.	Өмнөговь аймгийн байгаль орчны газар	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт		11 дүгээр сарын 01-нээс өмнө		Удирдлага Байгаль орчны мэргэжилтэн	Өмнөговь аймгийн байгаль орчны газарт
3.	Гурвантэс сумын ЗДТГ-т	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг иргэдийн		11 дүгээр сарын 01-нээс өмнө		Удирдлага	Өмнөговь аймгийн Гурвантэс

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах				Байгаль орчны мэргэжилтэн	сумын ЗДТГ-т
	Нийт				100,000		

**ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН**

13. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ НИЙТ ТӨСӨВ

№	Бүрэлдэхүүн хэсгийн нэр	Төсөв
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	14,585,000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4,000,000
3.	Осол эрсдэл	3,000,000
4.	Хог хаягдал	6,110,000
5.	Орчны хяналт шинжилгээ	3,500,000
6.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500,000
7.	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	100,000
Нийт		31,795,000

Хүсэлтийн лавлах дугаар: S55113322202506033

Татсан огноо: 2025-06-03 15:37

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
5205153324 MN670015005205153324	100900013406	15,897,500.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ӨНӨД ТҮНШ ХХК	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга ӨНӨД ТҮНШ 3655318 БОМТ 2025 ОНЫ БАР ЫЦАА,БО НӨХӨН	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-06-03	

